

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
СТРАТЕГИ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН  
ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭСТ  
САЛБАРЫН СУДАЛГАА МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**

2019 оны 12 дугаар сарын 02 өдөр

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт, “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1.3.2, 2.1-д заасны дагуу **Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Мэдээллийн сүлжээ, программ хангамж хариуцсан мэргэжилтэний** сонгон шалгаруулах зарыг олон нийтэд мэдээлж байна.

Сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-д заасны дагуу зохион байгуулж явуулна.

**Нэг. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэх иргэнд тавигдах болзол**

- Монгол Улсын иргэн байх;
- Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй;
- Сэтгэцийн өвчин, эмгэггүй;
- Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан байх.

**Хоёр. Албан тушаалд тавигдах тусгай шаардлага**

| Албан тушаалд тавигдах тусгай шаардлага: <b>Эрхэлсэн түшмэл, Т3-07</b> |  |  |
|--|--|--|
| <b>Боловсрол</b>   | -Дээд боловсролтой                                   |  |
| <b>Мэргэжил</b>  | -Албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй байх |  |
| <b>Мэргэшил</b>  | - мэдээллийн технологи, программ хангамж             |  |
| <b>Туршлага</b>  | - Мэргэжлээрээ 1-2 жил ажилласан байх                |  |
| <b>Ур чадвар</b>   | Дүн шинжилгээ хийх                                   | -Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах<br>-Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах   |
|  | Асуудал шийдвэрлэх                                   | -Байгууллагын чиг үүргийн хэрэгжилтэд өөрийн ажил үүргийн оруулах хувь нэмэр, оролцоог ойлгодог<br>-Өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг |
|  | Багаар ажиллах                                       | -Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах<br>-Багийн хүрээнд өөрт ногдсон үүргээ гүйцэтгэх              |
|  | Бусад  | - -Гадаад хэл, мэдээллийн технологийн болон бусад зайлшгүй шаардлагатай ур чадвар <sup>[8]</sup>   |

## **Гурав. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг:**

Уг ажлын байрны сонгон шалгаруулалтад Төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид болон төрийн албаны нөөцөд байгаа иргэд бүртгүүлэх боломжтой бөгөөд "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 2.2-т заасан дарааллын дагуу нөхнө. *(Төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид бүртгүүлээгүй тохиолдолд нөөцөд байгаа иргэдээс сонгон шалгаруулна. Төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид бүртгүүлсэн тохиолдолд нөөцөд байгаа иргэд сонгон шалгаруулалтад оролцох боломжгүй болохыг анхаарна уу.)*

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт заасны дагуу ажилласан жилийг тогтоосон тусгай шаардлагын 50 хувийг хангасан төрийн албан хаагчийг "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам"-аар шатлан дэвшүүлж болно.

- Төрийн албан хаагчийн анкет "А хэсэг" болон "Б хэсэг";
- Шалгалтад бүртгүүлэхээр бичгээр гаргасан хүсэлт;
- Иргэний үнэмлэхийн хуулбар, эх хувийн хамт;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн хуулбар, эх хувийн хамт; /Хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах/
- Нийгмийн даатгалын дэвтэр (Хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар, эх хувийн хамт; /албан тушаалын тодорхойлолтын туршлагын шаардлагад заасны дагуу туслах түшмэлийн ангилалд ажилласныг нотлох тушаал, шийдвэрийг холбогдох байгууллагаас хуулбарлан авч ирэх бөгөөд байгууллагын "Хуулбар үнэн" тэмдгээр баталгаажуулах;
- "4 х 6"-ийн хэмжээний 2 хувь цээж зураг;
- 2017 - 2019 оны төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас. /холбогдох байгууллагаас авч ирэх бөгөөд байгууллагын "Хуулбар үнэн" тэмдгээр баталгаажуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд холбогдох баримт;
- Шалгалтын үйлчилгээний зардал.

Дээр заасан баримт бичгийг дутуу бүрдүүлсэн, зохих ёсоор бүрдүүлээгүй иргэнийг бүртгэхгүй.

## **Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах ба бүртгэх**

Сонгон шалгаруулалтад оролцох төрийн жинхэнэ албан хаагчийн хүсэлт болон бүрдүүлсэн баримт бичгийг **Засгийн газрын II байр, УУХҮЯ-ны II давхарт 203 тоотод 2019 оны 12 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд комисс хүлээн авна.**

Сонгон шалгаруулалтад бүртгүүлэх болзлыг хангаж, холбогдох баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн албан хаагчийг бүртгэх тухай шийдвэрийг комисс хуралдаанаараа гаргах бөгөөд болзол хангаагүй бол энэ тухай шалтгааныг мэдэгдэнэ.

## **Тав. Сонгон шалгаруулалтын хуваарь**

Сонгон шалгаруулалтыг **2019 оны 12 дугаар сарын 20-ний өдөр** дараах агуулгын хүрээнд зохион байгуулна.

1. Тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэг;
2. Дүн шинжилгээ хийх чадвар
3. Асуудал шийдвэрлэх чадвар;
4. Монгол хэлний ярианы болон бичгийн чадвар;
5. Удирдан зохион байгуулах чадвар;
6. Манлайлах чадвар;
7. Багаар ажиллах чадвар;
8. Оролцогчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин.

Төрийн жинхэнэ албаны туслах түшмэлийн сонгон шалгаруулалтад оролцох иргэн “Иргэний цахим үнэмлэх” биедээ авч ирэхийг анхаарна уу.

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**  
**Холбоо барих утас: 51-264054, 51-260864**



